

ОРЧУУЛГА, НИЙТЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТОМИЛОЛТООР
ИРЖ АЖИЛЛАВ**

1983 оны соёлын харилцааны төлөвлөгөөний дагуу ЗХУ-ын ШУА-ийн Алс Дорнодын Институтийн тасгийн эрхлэгч, дэд эрдэмтэн Р. М. Асланов, мөн Институтийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд эрдэмтэн Е. Д. Степанов, БНСВУ-ын Нийгмийн Ухааны Хорооны Ази, Номхон далайн судлалын газрын дарга Ван Чонг, БНПАУ-ын ШУА-ийн социалист орнуудын Институтийн тасгийн эрхлэгч, доктор Р. Славиньски, Чехословакийн ШУА-ийн Дорнодахины Институтийн эрдэм шинжилгээний ажилтан Л. Халоупкова нар тус хүрээлэнд эрдэм шинжилгээний томилолтоор ирж ажиллав.

Нөхөр Е. Д. Степанов БНХАУ-ын хилийн бодлого. Р. М. Асланов Хятадын коммунист нам ба олон улсын хувьсгалт хөдөлгөөн, нөхөр Ван Чонг Вьетнам-Хятадын харилцаа, Р. Славиньски Хятад дахь феодализмын түүхийн асуудлаар, Л. Халоупкова Чехословакийн ШУА-ийн дэргэдэх Дорнодахины судлалын нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар тус тус сонирхолтой лекц яриа тус хүрээлэнд хийв.

Тэдгээр нөхөд тус хүрээлэн болон Улсын нийтийн номын санд ажиллаж, мөн нийслэлийн музей, соёл, урлаг, үйлдвэрийн зарим газрыг үзэв.